



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.04.30

Улаанбаатар хот

Хурал 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 11:15 цагт Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, Эрчим хүчний зүүн талд, үйлдвэрийн байрны хурлын өрөөнд эхэллээ.

Хурлыг хурлын дарга П.Оюунхүү удирдав.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирц 57.2%-тай байгааг тооллогын комисс танилцуулсанаар хурлын ирц хуулийн заалтад заасан хувьд хүрсэн тул хурал эхлэв.

П.Оюунхүү: /хурлын дарга/ - Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо, хувийг танилцуулав. Үүнд:

1. Д.Эрдэнэбилэг- 38220ш – 19.9%
2. П.Оюунхүү- 37221ш – 19,5%
3. Д.Эрдэнэтулга- 33752 – 17,6%
4. О.Оюунцэцэг- 333 – 0,2%- тайгаар оролцож байна.

Д.Эрдэнэбилэг: -Одоо хурлын тэргүүлэгчдийг сонгоё, хэнд ямар санал байна вэ?

Д.Эрдэнэтулга: -Хурлын тэргүүлэгчээр Д.Эрдэнэбилэг, О.Оюунцэцэг, Д.Баярсайхан нарыг сонгох саналтай байна.

П.Оюунхүү: -Өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй бол дээрхи гишүүдийг сонгох уу?

Санал нэгтэй сонголоо. Хурлыг удирдах тэргүүлэгчдэд:

1. Д.Эрдэнэбилэг
2. О.Оюунцэцэг
3. Д.Баярсайхан нар сонгогдлоо.

Хурлын тэргүүлэгчдийг байраа эзлэн сууж хурлаа удирдахыг урьлаа.

Хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг ажилдаа орохыг урьж байна.

П.Оюунхүү: Хуралд хэлэлцэх асуудлаа танилцуулж батлуулах ажилдаа ороё.



Хурлын тэргүүлэгч Д.Эрдэнэбилэг: Бүх гишүүдэд хурлын дараалал, дэгийг танилцууллаа.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зорилго, зорилтын талаар Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэг

2. Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийн талаар Нягтлан бодогч Э.Оюунцэцэг

3. Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх, ТУЗ-ийн гишүүдийг сонгох талаар Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэг

4. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал шүүмжлэл

Эдгээр асуудлыг хэлэлцүүлэхээр санал оруулж байна. Өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй бол хэлэлцэх асуудлаа батлах уу?

Гишүүд: Өөр санал байхгүй, хэлэлцэх асуудлаа батлая.

Хэлэлцэх асуудлаа гишүүдийн 100%-ийн саналаар баталлаа.

Д.Эрдэнэбилэг: -Одоо хурлын дэгээ танилцуулж батлуулъя.

1. 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын талаар

Д.Эрдэнэбилэг- Хугацаа 10 минут

2. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт

Э.Оюунцэцэг- Хугацаа 10 минут

3. Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх, ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хугацаа 20 минут

4. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал шүүмжлэл

Хугацаа 20 минут

Хурлыг 2025 оны 04 сарын 30 ны өдрийн 11:00 цагаас эхлэн 12:30 цагт дуусгана.

Хурлын дэгийг батлах уу? Өөр ямар нэг санал байна уу?

Д.Баярсайхан: -Өөр санал байхгүй дэгээ батлая.

Д.Эрдэнэбилэг: Гишүүдийн 100%-ийн саналаар дэгээ баталлаа.

Хурлын тэргүүлэгчдийн зүгээс эхний хоёр тайланг сонссоны дараа санал хүсэлтээ гаргаад явъя гэсэн саналыг оруулж байна. Та нөхөд зөвшөөрөх үү?



Гишүүд: Саналыг зөвшөөрлөө.

Д.Баярсайхан /хурлын тэргүүлэгч/: -Одоо хэлэлцэх асуудлын дагуу 2024 онд хийж гүйцэтгэсэн ажил 2025 оны зорилго, зорилтын талаар Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэгийн тайланг сонсоё. /Тайланг хавсаргав/

Д.Баярсайхан: -За тайлангаа танилцуулсан Д.Эрдэнэбилэг захиралдаа баярлалаа.

Д.Эрдэнэбилэг /хурлын дарга/: -2024 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн талаар нягтлан бодогч Э.Оюунцэцэгийн тайланг сонсоё. /Тайланг хавсаргав /

Д.Эрдэнэбилэг: -Тайлангаа танилцуулсан Э.Оюунцэцэгт баярлалаа.

Одоо дээрхи хоёр тайлантай холбогдсон санал, шүүмжлэлдээ ороё.

Д.Эрдэнэбилэг: -Сайн байцанаа уу? Та бүгдийг хурлаа хүндэтгэн, цаг заваа зориулж ирсэнд баярлалаа. 2024 онд хийж гүйцэтгэсэнд ажлын тайлангаас та бүхэнд асуух асуулт, санал хүсэлт хэлэх зүйл байвал хэлж бидний ажилд тусламж дэмжлэгээ үзүүлнэ гэдэгт итгэж байна. 2024 онд санхүүгийн хувьд өр зээлээ багасгах тал дээр анхаарч ажилласан. Төр засгаас явуулж байгаа бодлогыг барьж ажиллаа. Төрийн оролцоо үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлөх, хил гаалийн хаалттай нөхцөл байдал, ачаа тээврийн үнийн хөөрөгдөлөөс болж бодит хүндрэлүүд гарч байлаа. Бид энэ бүхнийг өөрийн үйл ажиллагаандаа нийцүүлэн дотоод зохион байгуулалт, төлөвлөсөн төлөвлөгөөт бодлоготойгоо зохицуулан ажиллаж ирлээ.

Бидний хувьд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүндээ чанарын өндөр шаардлага тавьж ажилласаар ирсэн. Бид материалаа ноосон даавуугаар үйлдвэрлэх тал баттай зогсож 36% ноос 64% даавуугаар бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна. Ажилчдын нийгмийн асуудал, мэргэжилтэй боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Бид ашгийн төлөө яваагүй, 70 гаран жилийн түүхтэй ууган үйлдвэрээ хадгалах зорилготой ажиллаж ирлээ. Ирэх онд тохижилтын талаар ажилчдын нийгмийн асуудал, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийн талаар анхаарч ажиллана. Санхүүгийн тал дээр өр авлагаа багасгах санхүүгээ эрүүлжүүлэх тал дээр онцгой анхаарч, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хэвийн барьж явах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллана.

Г.Баярсайхан: /Эсгүүрийн мастер/ -Бид өнгөрсөн онд үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу ажиллаж ирсэн. Ажилчдын ур чадвар жилээс жилд сайжирч байгаа нь ажиглагдаж байгаа. Залуу халаа бэлтгэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Мэргэжлийн сургууль төгссөн хүүхдүүдээс сонгон авах хэрэгтэй. Илүү ихийг сэтгэж сайн ажиллацгаая.

О.Оюунцэцэг: Үйлдвэрлэл хариуцан ажиллаж байгаа хүний хувьд 2024 онд төлөвлөсөн ажлаа амжуулахын тулд хүч, нөөц бололцоогоо дайчлан ажиллаж ирлээ. 2020 онд дэлхий нийтээр тархсан COVID-19 цар тахлын улмаас олон дахин хөл хорио тогтоож үйлдвэрийн тогтвортой ажилд томоохон хүндрэл учруулж байна.

Д.Эрдэнэтулга: 2025 онд чанарын шаардлагад дэвшил гаргаж ажиллах, тоног төхөөрөмжийн шинэчлэлд анхаарч ажиллах шаардлагатай. Хүний нөөцийн тал дээр МСҮТ-ийн оёдолчин мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дадлагын хугацааг ихэсгэж, төгссөн суралцагч нарыг үйлдвэрийн үндсэн ажилтнаар ажилд авах талаар МСҮТ-тэй тогтвортой хамтарсан гэрээг хийх тал дээр анхаарах хэрэгтэй.



Д.Эрдэнэбилэг: Одоо дараагийн асуудалдаа ороё.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай.

Сонссон нь: -Монгол улсын компаний тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалтыг үндэслэн ТУЗ-ийн ердийн гишүүнд: П.Оюунхүү, Д.Эрдэнэбилэг, Д.Баярсайхан, Д.Эрдэнэтулга, О.Оюунцэцэг, Л.Цэцэгсайхан ТУЗ-ийн хараат бус гишүүнд: Ч.Амаржаргал, Т.Тунгалаг, Д.Эрдэнэчимэг нарыг сонгох санал оруулж санал хураалт явуулах

Д.Эрдэнэбилэг: -Дээрхи саналаас өөр санал гаргах хүн байна уу?

Д.Баярсайхан: -Байхгүй энэ хүмүүсээ ТУЗ-ийн гишүүдэд сонгоё.

Д.Эрдэнэтулга: -Өөр санал алгаа сонгоё. Санал хураалтаа явуулъя.

Д.Эрдэнэбилэг: -За өөр санал хүсэлтэй хүн байна уу? Байхгүй бол санал хураалтандаа ороё. Тооллогын комисс саналын хуудсаа өгнө үү.

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдийн саналыг кумулятив аргаар явуулж

ТУЗ-ийн ердийн гишүүнд:

П.Оюунхүү-109,526ш
Д.Эрдэнэбилэг-109,526ш
Д.Баярсайхан-109,526ш
Д.Эрдэнэтулга-109,526ш
О.Оюунцэцэг-109,526ш
Л.Цэцэгсайхан-109,526ш

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

Ч.Амаржаргал-109,526ш
Д.Эрдэнэчимэг-109,526ш
Т.Тунгалаг-109,526ш саналаар сонгогдлоо.

Д.Эрдэнэбилэг: -Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээ баяр хүргэе. Ажлын амжилт хүсэе. Та бүгдийн үнэтэй санал зөвлөмжийг сонслоо маш их баярлалаа. Ажилдаа тусгаж ажиллах болно. Цаашид та бүхнийг хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Та бүгдэд ажлын амжилт эрүүл энх сайн сайхныг хүсэе.

Хурлаас гарах тогтоолыг уншиж танилцуулав. / Тогтоолыг хавсаргав. /

Хурал 12:30 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ОЮУНХҮҮ

Ч.Амаржаргал
Ч.АМАРЖАРГАЛ ТАМИР